



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160

Утас/Факс: (976-51) 26 75 33,

Цахим шуудан: info@mojha.gov.mn,

Цахим хуудас: www.mojha.gov.mn

2024.10.03 № 1/1079

танай 2024.09.20 ны № 1/1111 -т

**БОЛОВСРОЛЫН САЙД
П.НАРАНБАЯР ТАНАА**

“Журам шинэчлэн батлах тухай”
Боловсролын сайдын 2024 оны 09 дүгээр сарын
19-ний өдрийн А/95 дугаар тушаалыг Захиргааны
ерөнхий хуулийн дагуу хянан үзээд, захиргааны
хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн
.....6947..... дугаарт бүртгэснийг үүгээр хүргүүлж
байна.



О.АЛТАНГЭРЭЛ

151603647
Doc.yam a5.2024

Handwritten signature

12180307

Захиргааны хэм хэмжээний
актын улсын нэгдсэн бүртгэлд
2024 оны 10 сарын 04-ны
өдрийн 6947 дугаарт бүртгэв.



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛЫН
САЙДЫН ТУШААЛ

2024 оны 09 сарын 19 өдөр

Дугаар А/95

Улаанбаатар хот

Г Журам шинэчлэн батлах тухай Г

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Боловсролын ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хүүхдийн цэцэрлэгийн багш, арга зүйч, эрхлэгчид мэргэшлийн зэрэг олгох, хүчингүй болгох журмыг нэгдүгээр хавсралтаар, ерөнхий боловсролын сургуулийн багш, удирдах ажилтанд мэргэшлийн зэрэг олгох, хүчингүй болгох журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2. Тушаалын хэрэгжилтийг удирдлагаар хангаж ажиллахыг Боловсролын ерөнхий газар (Т.Ням-Очир), аймаг, нийслэлийн Боловсролын газрын дарга нарт, тушаалыг хэрэгжүүлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулж, мэргэшлийн зэрэгтэй багш, ажилтныг боловсролын салбарын нэгдсэн мэдээллийн системд бүртгэхийг төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч нарт тус тус даалгасугай.

3. Мэргэшлийн зэрэг олгох, хүчингүй болгох явцыг боловсролын нэгдсэн мэдээллийн системд бүртгэх, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Цахим боловсролын газар (Т.Бат-Эрдэнэ)-т даалгасугай.

4. Тушаалын хэрэгжилтэд 2 жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж танилцуулахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар (Н.Нарангэрэл)-т даалгасугай.

5. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны "Журам батлах тухай" А/854 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

П.НАРАНБАЯР



14241 0306

Боловсролын сайдын
2024 оны 09 дүгээр сарын 19 ны өдрийн
495 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН БАГШ, УДИРДАХ АЖИЛТАНД МЭРГЭШЛИЙН ЗЭРЭГ ОЛГОХ, ХҮЧИНГҮЙ БОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг зүйл

1.1.Хүүхдийн цэцэрлэг (цаашид “цэцэрлэг” гэх)-ийн багш, арга зүйч, эрхлэгчид мэргэшлийн зэрэг олгох, хүчингүй болгохтой холбогдох харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2.Мэргэшлийн зэрэг нь багш, арга зүйч, эрхлэгч (цаашид “багш, удирдах ажилтан гэх)-ийн албан тушаалын тодорхойлолт болон холбогдох хууль тогтоомжид заасан чиг үүргээ хэрэгжүүлж, үр дүнд хүрснийг баталгаажуулах, тэдний мэргэжлийн хөгжлийг дэмжихэд чиглэнэ.

1.3.Мэргэшлийн зэрэг олгох, хүчингүй болгох үйл ажиллагаа нь багш, удирдах ажилтны ур чадвар, манлайлал, ажлын үр дүнд суурилсан, бодитой, ил тод, хамтын оролцоог хангасан, аливаа хөндлөнгийн нөлөөлөл, ялгаварлан гадуурхалт болон ашиг сонирхлын зөрчлөөс ангид байна.

1.4.Мэргэшлийн зэрэг нь өмчийн бүх хэлбэрийн цэцэрлэгт нэгэн адил хүчинтэй байна.

Тайлбар: “мэргэшлийн зэрэг олгох, хүчингүй болгох” гэдэгт мэргэшлийн зэрэг шинээр олгох, баталгах (өмнө олгосон зэргийн шалгуурыг давтан хангаж байгааг баталгаажуулах), эсхүл ахиулах, хүчингүй болгох үйл ажиллагааг хамруулна.

Хоёр. Мэргэшлийн зэргийн шатлал, хүчинтэй хугацаа

2.1.Цэцэрлэгийн багш, удирдах ажилтны мэргэшлийн зэрэг нь “Заах аргач”, “Тэргүүлэх”, “Зөвлөх” гэсэн шатлалтай байна.

2.2.Мэргэшлийн зэргийн хүчинтэй хугацаа шатлал бүрд 5 жил байна.

2.3.“Заах аргач” мэргэшлийн зэрэгтэй багш нь мэргэжлээрээ 3-аас доошгүй жил ажилласан, энэхүү журамд заасан шалгуур, шаардлагыг хангасан, хамт олон, эцэг эх, асран хамгаалагчтай хамтран ажиллах, мэргэжлийн зөвлөгөө дэмжлэг үзүүлэх чадвартай, эерэг харилцаа хандлага, төлөвшилтэй байна.

2.4.“Тэргүүлэх” мэргэшлийн зэрэгтэй багш, удирдах ажилтан нь энэхүү журамд заасан шаардлага, шалгуурыг хангасан, байгууллага, орон нутгийн түвшинд мэргэжлийн багш нарын бүлэгт хамтран болон чиглүүлэн ажиллах, зөвлөгөө дэмжлэг үзүүлэх болон боловсролын сургалтын байгууллага, багшийн хөгжилд хувь нэмрээ оруулан манлайлан ажиллах чадвартай байна.

Бүртгэлийн дугаар . 72

МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛЫН ЯАМ
ATA12960 9116621

ХУУЛБАР ҮНЭН

Хуулбар олгосон ажилтны гарын үсэг

2024 оны 09 сарын 19-ний өдөр

2.5. "Зөвлөх" мэргэшлийн зэрэгтэй багш, удирдах ажилтан нь энэхүү журамд заасан шаардлага, шалгуурыг хангасан, орон нутаг, үндэсний түвшинд мэргэжлийн багш нарын бүлгийг удирдан чиглүүлэх, зөвлөгөө дэмжлэг үзүүлэх болон боловсролын сургалтын байгууллага, багшийн хөгжилд хувь нэмрээ оруулан манлайлан ажиллах чадвартай байна.

2.6. Мэргэшлийн зэргийг шатлал алгасан олгохгүй.

2.7. Мэргэшлийн зэрэг олгосныг нотлох баримт бичиг нь мэргэшлийн зэрэг олгосон эрх бүхий албан тушаалтны шийдвэр байна.

2.8. Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийн 9.2-д заасныг үндэслэн 2.8.1, 2.8.2, 2.8.3-т заасан шалгуураас хангасан тохиолдолд мэргэшлийн зэргийг хугацаанаас өмнө олгож болно:

2.8.1. Орон нутаг, үндэсний түвшинд мэргэжлийн багш нарын бүлгийг удирдан чиглүүлж, үр дүнд хүрсэн;

2.8.2. Орон нутаг, үндэсний түвшинд шинэлэг сургалтын арга зүйг туршин хэрэгжүүлж, үр дүнд хүрсэн;

2.8.3. Үндэсний болон олон улсын эрдэм шинжилгээний хурал, зөвлөгөөнд илтгэл хэлэлцүүлсэн (тухайн илтгэл нийтлэгдсэн байх);

2.9. Энэ журмын 5.4.1-т заасан үндэслэлээр мэргэшлийн зэргийн хүчингүй байх хугацаа нь 1 жил байна.

Гурав. Мэргэшлийн зэрэг олгох шалгуур

3.1. Мэргэшлийн зэргийг дараах шаардлага болон энэ журмын 3.2-т заасан шалгуур хангасан багш, удирдах ажилтанд олгоно.

3.1.1. Багш мэргэжилтэй байх;

3.1.2. Цэцэрлэгт багшаар гурваас доошгүй жил ажилласан байх;

3.1.3. Сүүлийн нэг жилийн хугацаанд ёс зүйн зөрчил болон мэргэжлийн алдаа гаргаагүй байх;

3.1.4. Мэргэшлийн зэрэг олгох, бататгах саналыг багш нарын зөвлөлийн хуралд оролцогчдын 80.0-аас доошгүй хувь нь дэмжсэн байх;

3.2. Энэ журмын 3.2.1, 3.2.2, 3.2.3-д заасан шалгуурыг бүрэн хангасан багш, удирдах ажилтанд мэргэшлийн зэрэг олгоно.

3.2.1. Багшид мэргэшлийн зэрэг олгох, бататгахад дараах шалгуурыг баримтална:



Шалгуур	Мэргэшлийн зэргийн шатлал		
	Заах аргач	Тэргүүлэх	Зөвлөх
	Үзүүлэлт		
Хүүхдийн хөгжлийн ахиц	<p>-Явцын болон үр дүнгийн үнэлгээгээр хүүхдийн хөгжилд ахиц гарсан байх;</p> <p>-Хүүхдийн онцлог, ялгаатай хэрэгцээнд суурилсан арга зүйг боловсруулан сургалт, үйл ажиллагааг зохион байгуулж, үр дүнд хүрсэн байх;</p>		<p>- Явцын болон үр дүнгийн үнэлгээгээр хүүхдийн хөгжилд ахиц гарсан байх;</p> <p>-Хүүхдийн хөгжлийн үнэлгээний сайн туршлагыг орон нутаг болон бүс нутгийн хэмжээнд түгээн дэлгэрүүлсэн байх;</p> <p>-Хүүхдийн онцлог, ялгаатай хэрэгцээнд суурилсан арга зүйг боловсруулан хэрэгжүүлж, үр дүнг орон нутаг болон бүс нутгийн хэмжээнд түгээн дэлгэрүүлсэн байх;</p>
	<p>-Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүй, технологийг эзэмшиж, бүтээлчээр хэрэгжүүлэн үр дүнд хүрсэн байх;</p>	<p>-Сургалт, үйл ажиллагааны чанар, үр дүнг сайжруулах 2-оос доошгүй арга зүй, технологийг эзэмшиж, бүтээлчээр хэрэгжүүлж, үр дүнд шинжилгээ хийсэн байх;</p>	<p>-Сургалт, үйл ажиллагааны чанар, үр дүнг сайжруулах 3-аас доошгүй арга зүй, технологийг бүтээлчээр хэрэгжүүлж, үр дүнд хүрсэн байх;</p> <p>-Цэцэрлэгийн хүүхдийн хөгжилд гарсан ахиц, өөрчлөлтөд дүн шинжилгээ хийж, сайжруулах чиглэлээр төлөвлөлт хийн, үр дүнд хүрсэн байх;</p>
Багшийн мэргэжлийн хөгжил, хамтын ажиллагаа	<p>-Багшийн хувийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж, үр дүнг тооцсон байх;</p> <p>-Ажлын байранд мэргэжил, арга зүй, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэн ахиц гарсан байх;</p>	<p>-Багшийн хувийн хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлж, үр дүнг тооцсон байх;</p> <p>-Ажлын байранд мэргэжил, арга зүй, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэн, сургалт, үйл ажиллагаандаа ашиглаж, үр дүнд ахиц гарсан байх;</p>	<p>-Багшийн хувийн хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлж, үр дүнг тооцсон байх;</p> <p>-Ажлын байрандаа мэргэжил, арга зүй, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэн, шинэлэг санаа, бүтээлч арга зүй, дэвшилтэт технологийг хэрэгжүүлэн түгээн дэлгэрүүлсэн байх;</p>

АТА12960 916621
ХУУЛБАР ҮНЭН
 Хуулбар олгосон ажилтны гарын үсэг
 20 21 оны 09 сарын 27-ний өдөр

	-Цэцэрлэгийн мэргэжлийн багш нарын бүлгийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, хамтран ажилласан байх;	-Цэцэрлэгийн мэргэжлийн багш нарын бүлгийг чиглүүлэн, багшид мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж, үр дүнг тооцсон байх;	-Мэргэжлийн багш нарын 3-аас доошгүй бүлгийг чиглүүлэн, багшид мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж, үр дүнг тооцсон байх;
Хамт олон, эцэг эх асран хамгаалагчийн сэтгэл ханамж	-Суралцагч, эцэг, эх, асран хамгаалагч, багш, ажилтантай ёс зүйтэй, шударга, адил тэгш харилцаж, ажил, үүргээ гүйцэтгэхэд нь тусалж дэмждэг байх -Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжихэд чиглэсэн үйл ажиллагааг эцэг эх, асран хамгаалагчдад зориулан зохион байгуулж, үр дүнг тооцсон байх. - Багшийн ёс зүй, харилцааны зөрчилгүй, бусадтай хамтран болон манлайлан ажилладаг нь хамт олны үнэлгээгээр нотлогдсон байх -Хүүхэд хамгааллын болон цэцэрлэгийн дэмжлэгийн баг, эцэг эх, асран хамгаалагчтай хамтран ажиллаж үр дүнд хүрсэн байх;		

3.2.1.1 “Багшийн хөгжлийг дэмжих үндэсний төв”-ийн арга зүйн эхний шатны сургалтад хамрагдаж, амжилттай төгссөн тохиолдолд “Заах аргач” мэргэшлийн зэргийн “Багшийн мэргэжлийн хөгжил, хамтын ажиллагаа” шалгуурыг хангасанд тооцно.

3.2.1.2 “Багшийн хөгжлийг дэмжих үндэсний төв”-ийн арга зүйн ахисан түвшний сургалтад хамрагдаж, амжилттай төгссөн тохиолдолд “Тэргүүлэх”, “Зөвлөх” мэргэшлийн зэргийн “Багшийн мэргэжлийн хөгжил, хамтын ажиллагаа” шалгуурыг хангасанд тооцно.

3.2.2. Арга зүйчид мэргэшлийн зэрэг олгох, бататгахад дараах шалгуурыг баримтална:

Шалгуур	Мэргэшлийн зэргийн шатлал		
	Заах аргач	Тэргүүлэх	Зөвлөх
	Үзүүлэлт		
Хүүхдийн хөгжлийн ахиц	- Цэцэрлэгийн хүүхдийн хөгжилд гарсан ахиц, өөрчлөлтөд дүн шинжилгээ хийж, сайжруулах чиглэлээр төлөвлөлт хийн, үр дүнд хүрсэн байх; -Хүүхдийн онцлог, ялгаатай хэрэгцээг харгалзан сургалт, үйл ажиллагааг зохион байгуулах талаар багш нарт арга зүйн дэмжлэг үзүүлж, үр дүнд хүрсэн байх;	- Цэцэрлэгийн хүүхдийн хөгжилд гарсан ахиц, өөрчлөлтөд дүн шинжилгээ хийж, сайжруулах чиглэлээр төлөвлөлт хийн, хүрсэн үр дүнг орон нутаг болон бүс нутгийн хэмжээнд түгээн дэлгэрүүлсэн байх; -Хүүхдийн онцлог, ялгаатай хэрэгцээг харгалзан шинэлэг арга зүйг боловсруулан, хэрэгжүүлж, үр дүнг түгээн дэлгэрүүлсэн байх.	

Бүртгэлийн дүгнэлт

МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛЫН ЯАМ
ATA12960 9116621
ХУУЛБАР ҮНЭН
Хуулбар олгосон ажилтны гарын үсэг
2024 оны 09 сарын 28 -ний өдөр

<p>Багшийн мэргэжлийн хөгжил, хамтын ажиллагаа</p>	<p>-Багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжих зорилгоор сургалт, үйл ажиллагаанд ажиглалт хийн багш нарт арга зүйн дэмжлэг, зөвлөгөөг тогтмол үзүүлсэн байх;</p> <p>-Цэцэрлэгийн өөрийн болон хөндлөнгийн үнэлгээний үр дүн, багшийн хөгжих хэрэгцээнд үндэслэн багшийн хөгжлийн үйл ажиллагааг төлөвлөн үр дүнтэй хэрэгжүүлдэг байх;</p> <p>-Мэргэжлийн багш нарын бүлэг, хамтын ажиллагааг дэмжих сургалт, үйл ажиллагааг байгууллагын түвшинд 2-оос доошгүй удаа зохион байгуулж, үр дүнг тооцсон байх;</p>	<p>-Багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжих зорилгоор сургалт, үйл ажиллагаанд ажиглалт хийн багш нарт арга зүйн дэмжлэг, зөвлөгөөг тогтмол үзүүлж, үр дүнд хүрсэн байх;</p> <p>-Цэцэрлэгийн өөрийн болон хөндлөнгийн үнэлгээний үр дүн, багшийн хөгжих хэрэгцээнд үндэслэн багшийн хөгжлийн үйл ажиллагааг төлөвлөн үр дүнтэй хэрэгжүүлдэг байх;</p> <p>-Багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжих сургалт, үйл ажиллагааг орон нутгийн түвшинд зохион байгуулж, үр дүнг тооцсон байх;</p> <p>-Мэргэжлийн багш нарын бүлгийн ажлыг чиглүүлэн, бүтээлч арга зүй, туршлагыг түгээн дэлгэрүүлсэн байх;</p>	<p>-Багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжих зорилгоор сургалт, үйл ажиллагаанд ажиглалт хийн багш нарт арга зүйн дэмжлэг, зөвлөгөөг тогтмол үзүүлж, хүрсэн үр дүнг орон нутаг болон бүс нутгийн хэмжээнд түгээн дэлгэрүүлсэн байх;</p> <p>-Цэцэрлэгийн өөрийн болон хөндлөнгийн үнэлгээний үр дүн, багшийн хөгжих хэрэгцээнд үндэслэн багшийн хөгжлийн үйл ажиллагааг төлөвлөн үр дүнтэй хэрэгжүүлдэг байх;</p> <p>-Багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжих сургалт, үйл ажиллагааг орон нутаг болон бүс нутгийн түвшинд зохион байгуулж, үр дүнг тооцсон байх;</p> <p>-Мэргэжлийн багш нарын бүлгийн ажлыг чиглүүлэн, 2-оос доошгүй бүтээлч арга зүй, туршлагыг түгээн дэлгэрүүлсэн байх;</p>
<p>Хамт олон, эцэг эх асран хамгаалагчийн сэтгэл ханамж</p>	<p>- Эцэг, эх, асран хамгаалагч, багш, ажилтнуудтай эерэг, ёс зүйтэй, шударга, тэгш харилцдаг, тусалж дэмждэг байх;</p> <p>- Эцэг, эх, асран хамгаалагч, багш, ажилтанд зориулан бага насны хүүхдийн хөгжлийг дэмжихэд чиглэсэн үйл ажиллагааг хамтран зохион байгуулж, үр дүнг тооцсон байх;</p> <p>-Хүүхэд хамгаалал болон цэцэрлэгийн дэмжлэгийн баг, гэр бүл, иргэн, байгууллагатай хамтран ажиллаж үр дүнд хүрсэн байх;</p> <p>-Ажилтны ёс зүй, харилцааны чадварыг үнэлсэн хамт олны үнэлгээ.</p>		

3.2.2.1."Багшийн хөгжлийг дэмжих үндэсний төв"- ийн манлайллын эхний шатны сургалтад хамрагдаж, амжилттай төгссөн тохиолдолд "Заах аргач" мэргэшлийн зэргийн "Багшийн мэргэжлийн хөгжил, хамтын ажиллагаа" шалгуурыг хангасанд тооцно.

3.2.2.2."Багшийн хөгжлийг дэмжих үндэсний төв"- ийн манлайллын ахисан түвшний сургалтад хамрагдаж, амжилттай төгссөн тохиолдолд "Тэргүүлэх" ба "Зөвлөх" мэргэшлийн зэргийн "Багшийн мэргэжлийн хөгжил, хамтын ажиллагаа" шалгуурыг хангасанд тооцно.



3.2.3. Эрхлэгчийн “Тэргүүлэх” зэргийг бататгах, “Зөвлөх” зэрэг олгох, бататгахад дараах шалгуурыг баримтална:

Шалгуур	Мэргэшлийн зэргийн шатлал	
	Тэргүүлэх	Зөвлөх
	Үзүүлэлт	
Байгууллагын менежмент	<p>-Байгууллагын стратеги болон гүйцэтгэлийн төлөвлөгөөг хамтын оролцоотой боловсруулан, хэрэгжүүлж, үр дүнг тооцсон байх;</p> <p>-Байгууллагын өөрийн болон хөндлөнгийн үнэлгээний үр дүнд үндэслэн үйл ажиллагаагаа сайжруулан, ажлын үр дүнг тооцсон байх;</p> <p>-Багш, ажилтны ажлын гүйцэтгэл, үр дүнд шинжилгээ хийж хэрэгцээнд нь тулгуурласан үр дүнтэй ажил зохион байгуулж, чанар, үр дүнг тооцсон байх;</p>	<p>-Байгууллагын стратеги болон гүйцэтгэлийн төлөвлөгөөг хамтын оролцоотой боловсруулан хэрэгжүүлсэн байх;</p> <p>-Байгууллагын өөрийн болон хөндлөнгийн үнэлгээний үр дүнд үндэслэн үйл ажиллагаагаа сайжруулан, ажлын үр дүнг тооцсон байх;</p> <p>-Байгууллагын менежментийн төлөвлөлт, хэрэгжилтэд судалгаа, шинжилгээ хийж, үр дүнг тооцон, 3-аас доошгүй удаа сургалт, үйл ажиллагааг орон нутаг болон бүс нутгийн түвшинд зохион байгуулсан байх;</p>
Багшийн мэргэжлийн хөгжил, хамтын ажиллагаа	<p>Цэцэрлэгийн хүүхдийн хөгжилд гарсан ахиц, өөрчлөлтөд үндэслэн сайжруулах чиглэлээр хийсэн төлөвлөлт, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, үр дүнд хүрсэн байх;</p> <p>-Хүүхдийн хөгжил, хамгаалал, тэгш хамран сургах чиглэлээр багш, ажилтан, эцэг эх, асран хамгаалагчдад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлсэн байх;</p> <p>-Багш нарын зөвлөл, мэргэжлийн багш нарын бүлгийн ажлыг чиглүүлэн, 2-оос доошгүй сайн туршлагыг түгээн дэлгэрүүлсэн байх;</p> <p>-Байгууллагын болон багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжих чиглэлээр сургалт, үйл ажиллагааг орон нутгийн түвшинд 2-оос доошгүй удаа зохион байгуулж, үр дүнг тооцсон байх;</p>	<p>-Цэцэрлэгийн хүүхдийн хөгжилд гарсан ахиц, өөрчлөлтөд үндэслэн сайжруулах чиглэлээр хийсэн төлөвлөлт, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, үр дүнд хүрсэн байх;</p> <p>Хүүхдийн хөгжил, хамгаалал, тэгш хамран сургах чиглэлээр багш, ажилтан, эцэг эх, асран хамгаалагчдад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлсэн байх;</p> <p>-Багш нарын зөвлөл, мэргэжлийн багш нарын бүлгийн ажлыг чиглүүлэн, 3-аас доошгүй сайн туршлагыг орон нутаг болон бүс нутгийн түвшинд түгээн дэлгэрүүлсэн байх;</p> <p>-Байгууллагын болон багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжих чиглэлээр сургалт, үйл ажиллагааг орон нутаг болон</p>

ХУУЛБАР ҮНЭН

Хуулбар олгосон ажилтны гарын үсэг

2024 оны 04 сарын 24-ний өдөр

МОНГОЛЫН БАШОРНЫ БАА
БОЛОВСРУУЛСАН
АТА12960 0116621

		бүс нутгийн түвшинд 3-оос доошгүй удаа зохион байгуулсан байх.
Сургалтын орчин	-Хүүхдийн хоол, хүнсний шим тэжээллэг байдал, эрүүл ахуй, технологийн горимыг хангах чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын үр дүн; -Сургалтын байгууллагын орчинд багш, ажилтан, бага насны хүүхдийн аюулгүй байдлыг хангах, аливаа эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх талаар авсан арга хэмжээ, үр дүн; -Цэцэрлэгийн сургалтын орчны стандартын шаардлага хангасан байдалд хамт олон, эцэг эх, асран хамгаалагч, олон нийтийн оролцоотой өөрийн үнэлгээ хийж, боловсролын үйлчилгээний чанар, үр дүнг тооцсон байх;	
Ёс зүй, манлайлал	- Эцэг, эх, асран хамгаалагч, багш, ажилтнуудтай эерэг, ёс зүйтэй, шударга, тэгш харилцдаг, тусалж дэмждэг, манлайлан ажилладаг байх; -Хамт олны хөгжил, байгууллагын соёл, сайн туршлагаа орон нутаг, бүс, үндэсний түвшинд түгээсэн байх; -Хүүхэд хамгаалал, дэмжлэгийн баг, гэр бүл, иргэн, байгууллагатай хамтран ажиллаж үр дүнд хүрсэн байх; -Удирдах ажилтны ёс зүй, харилцааны чадварыг үнэлсэн хамт олны үнэлгээ.	

3.2.3.1."Багшийн хөгжлийг дэмжих үндэсний төв"-ийн манлайллын ахисан түвшний сургалтад хамрагдаж, амжилттай төгссөн тохиолдолд "Тэргүүлэх", "Зөвлөх" мэргэшлийн зэргийн "Багшийн мэргэжлийн хөгжил, хамтын ажиллагаа" шалгуурыг хангасанд тооцно.

Дөрөв. Мэргэшлийн зэрэг олгох, хүчингүй болгох үйл ажиллагааны зохион байгуулалт

4.1.Энэ журмын 4.4-т заасан ажлын хэсгийн санал, дүгнэлтэд үндэслэн багш, удирдах ажилтанд мэргэшлийн зэрэг олгох, хүчингүй болгох эсэх шийдвэрийг дараах эрх бүхий албан тушаалтан гаргана:

4.1.1."Заах аргач" мэргэшлийн зэргийг цэцэрлэгийн эрхлэгч;

4.1.2."Тэргүүлэх" мэргэшлийн зэргийг аймаг, нийслэлийн боловсролын газрын дарга;

4.1.3."Зөвлөх" мэргэшлийн зэргийг Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн;

4.2.Мэргэшлийн зэрэг олгох, бататгах хүсэлтийг багш, удирдах ажилтан томилох эрх бүхий албан тушаалтанд тухайн оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн дотор гаргана.

4.3.Багш, удирдах ажилтан дараах материалыг боловсролын мэдээллийн нэгдсэн системд цахим хэлбэрээр бүрдүүлнэ.

4.3.1.Мэргэшлийн зэрэг олгох, эсхүл бататгах талаар гаргасан хүсэлт;



4.3.2.Энэхүү журмын 3.2-т заасан шаардлага, шалгуурыг бүрэн хангасан болохыг нотлох баримт, мэдээлэл;

4.3.3.Мэргэшлийн зэрэгтэй тохиолдолд уг мэргэшлийн зэрэг олгосон эрх бүхий албан тушаалтны албан ёсны шийдвэрийн хуулбар;

4.4.Мэргэшлийн зэргийн хүсэлтийг журамд заасан шалгуурын дагуу магадлан, дүгнэлт гаргах 3-7 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсгийг тухайн мэргэшлийн зэрэг олгох шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтан томилно.

4.5.Ажлын хэсгийн дарга, гишүүд “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай” хуульд заасны дагуу “Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн эсэх тухай мэдэгдэл”-ийг мэргэшлийн зэрэг олгохтой холбогдох үйл ажиллагаа эхлэхийн өмнө батлагдсан маягтын дагуу гаргаж, ажлын хэсгийн даргад хүлээлгэн өгнө.

4.6.Энэ журмын 3.1, 3.2-т заасан шаардлага, шалгуурыг багш, удирдах ажилтан хангасан эсэхийг ажлын хэсэг нотлох баримтад үндэслэн магадлан хянаж, дүгнэлт гаргана.

4.6.1.Багш энэхүү журамд заасан шалгуурыг хангаж байгаа эсэх, мэргэшлийн зэрэг олгох, бататгах, хасах, хүчингүй болгохтой холбоотой дүгнэлтийг ажлын хэсгийн 90-ээс доошгүй хувийн оролцоотой дэмжсэн тохиолдолд дүгнэлтийг хүчинтэйд тооцно.

4.6.2.Шаардлагатай тохиолдолд багш, удирдах ажилтан нь тухайн мэргэшлийн зэргийн шалгуурыг хангаж буй эсэхийг ажлын байранд нь очиж магадлан шалгаж болно.

4.6.3.Мэргэшлийн зэрэг олгох, бататгах, хүчингүй болгох тухай гаргасан дүгнэлтийг мэргэшлийн зэрэг олгох эрх бүхий албан тушаалтанд танилцуулж шийдвэрлүүлэх, боловсролын мэдээллийн системд баталгаажуулах ажлыг гүйцэтгэнэ.

4.7.Мэргэшлийн зэрэг бататгах, шатлал ахиулах хүсэлтийг мэргэшлийн зэргийн хүчинтэй хугацаанд гаргана.

4.8.“Заах аргач”, “Тэргүүлэх” мэргэшлийн зэрэг олгосныг гэрчилсэн албан ёсны баталгаа нь энэ журмын 4.1.1, 4.1.2-т заасан эрх бүхий албан тушаалтны шийдвэр байна.

4.9.Энэ журмын 4.1.3-т заасан Засгийн газрын гишүүний шийдвэрт үндэслэн “Зөвлөх” зэрэг олгосон багш, удирдах ажилтанд мэргэшлийн зэргийн үнэмлэх олгоно.

4.10.Цэцэрлэгийн ажлын хэсэг нь багшийн цахимд байршсан баримт материалыг тухайн оны 04 дүгээр сард багтаан энэхүү журамд нийцүүлэн хянаж, дүгнэлтийг цэцэрлэгийн эрхлэгч, багш нарын зөвлөлд танилцуулна.

4.11.Цэцэрлэгийн эрхлэгч нь ажлын хэсгийн болон багш нарын зөвлөлийн хурлын дүгнэлтэд тус тус үндэслэн дараах шийдвэрийг 5 дугаар сарын эхний 7 хоногт багтаан гаргана:

4.11.1.багшид “Заах аргач” мэргэшлийн зэрэг олгох;



4.11.2.багшийн “Тэргүүлэх”, “Зөвлөх” мэргэшлийн зэргийн шалгуур хангасан байдал, арга зүйчийн мэргэшлийн зэргийн шалгуур хангасан байдлыг магадлан шалгуулах хүсэлтийг Боловсролын газарт хүргүүлэх;

4.12.Боловсролын газрын ажлын хэсэг нь багш, удирдах ажилтанд “Тэргүүлэх”, “Зөвлөх” мэргэшлийн зэрэг олгох шалгуурыг магадлан шалгаж, дүгнэлт гаргах болон энэ журмын 4.8-д заасан үйл ажиллагааг тухайн оны 5 дугаар сард багтаан зохион байгуулна.

4.12.1.багш, удирдах ажилтанд “Тэргүүлэх” мэргэшлийн зэргийн шаардлага, шалгуур хангасан эсэхэд дүгнэлт гаргах;

4.12.2.багш, удирдах ажилтанд “Тэргүүлэх” мэргэшлийн зэрэг олгох шийдвэр, арга зүйч нь “Заах аргач” мэргэшлийн зэргийг бататгах шалгуур шаардлагыг хангасан эсэх дүгнэлтийг цэцэрлэгийн эрхлэгчид хүргүүлэх;

4.12.3.“Зөвлөх” мэргэшлийн зэргийн шаардлага, шалгуур хангасан багш, удирдах ажилтны холбогдох хүсэлт, дүгнэлтийг Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад уламжилна.

4.13.Цэцэрлэгийн эрхлэгч нь 4.12.2-т заасан дүгнэлтэд үндэслэн арга зүйчид “Заах аргач” мэргэшлийн зэргийг бататган олгох шийдвэрийг жил бүрийн 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор гаргана.

4.14.Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас томилогдсон ажлын хэсэг нь “Зөвлөх” мэргэшлийн зэргийн дүгнэлтийг тухайн оны 06 дугаар сард багтаан гаргаж, Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ.

4.15.Энэ журмын 4.14-т заасан дүгнэлтэд үндэслэн багш, удирдах ажилтанд “Зөвлөх” мэргэшлийн зэргийг тухайн оны 9 дүгээр сард багтаан Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр олгоно.

4.16.Ажлын хэсгийн дүгнэлтээр “Тэргүүлэх”, “Зөвлөх” мэргэшлийн зэрэг шинээр олгох эсхүл бататгахад шалгуур, шаардлагыг хангаагүй буцаагдсан тохиолдолд боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллагын ажлын хэсэг өмнөх мэргэшлийн зэргийн шалгуурыг хангаж буй талаар дүгнэлт гарган тухайн оны 11 дүгээр сард багтаан баталгаажуулж болно.

4.17.Мэргэшлийн зэрэг олгох эрх бүхий албан тушаалтан нь ажлын хэсгийн гаргасан дүгнэлтийг баримт бичгийн бүрдэл хангуулахаар нэг удаа буцааж болох бөгөөд бусад тохиолдолд шалгуур хангаагүй багш, удирдах ажилтанд мэргэшлийн зэрэг олгохыг хориглоно.

4.18.Багш, ажилтны мэргэшлийн зэрэг олгох, бататгах хүсэлт болон бүрдүүлсэн баримт бичиг, ажлын хэсгийн дүгнэлт, мэргэшлийн зэрэг олгох шийдвэрийг ажлын хэсэг нь “Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль”-ийн дагуу баримт үүсгэж, хадгална. *7*

4.19.Цэцэрлэг нь мэргэшлийн зэргийн нэмэгдэлд шаардлагатай зардлыг дараа оны төсвийн төсөлд тусгаж, төлөвлөнө.



4.20.Цэцэрлэг нь мэргэшлийн зэрэг ахиулсан, шинээр авсан багш, удирдах ажилтанд мэргэшлийн зэргийн нэмэгдлийг дараа оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн эрх бүхий байгууллагаас тогтоосон хувь хэмжээгээр тооцож олгоно.

4.21.Мэргэшлийн зэргийн шатлал ахиулсан багш, удирдах ажилтанд энэ журмын 4.20-д заасан нэмэгдлийг авах хүртэл хугацаанд өмнөх хүчин төгөлдөр мэргэшлийн зэргийн нэмэгдлийг олгоно.

4.22.Өндөр насны тэтгэвэр тогтоолгоод цэцэрлэгт ажиллаж байгаа багш, удирдах ажилтны мэргэшлийн зэргийн хүчинтэй хугацаанд мэргэшлийн зэргийн нэмэгдлийг Хөдөлмөрийн тухай хуулийн 145 дугаар зүйлд заасны дагуу шийдвэрлэнэ.

Тав. Мэргэшлийн зэрэг хэвээр хадгалах, хүчингүй болгох

5.1.Багш, удирдах ажилтанд олгосон мэргэшлийн зэрэг дараах тохиолдолд хэвээр хадгалагдана.

5.1.1.Хөдөлмөрийн тухай хуулийн 137, 138, 139-д заасны дагуу жирэмсний, амаржсаны, хүүхэд асрах чөлөөтэй тохиолдолд 3 хүртэл жил;

5.1.2.Ажил олгогчийн зөвшөөрлөөр гадаад улсад мэргэжил дээшлүүлэх, магистр, докторын сургалтад хамрагдаж байгаа тохиолдолд 3 хүртэл жил;

5.1.3.Цэргийн жинхэнэ албанд татагдсан тохиолдолд 1 жил;

5.1.4.Боловсролын ерөнхий хуулийн 17.1, 25.1, 27.1, 28.1-д заасан байгууллагад удирдах болон гүйцэтгэх албан тушаалд дэвшин, шилжин ажилласан тохиолдолд 3 хүртэл жил;

5.1.5.Өөрийн болон гэр бүлийн гишүүний эрүүл мэндийн байдлын улмаас ажил олгогчоос чөлөө авсан тохиолдолд 1 жил хүртэл;

5.2.“Тэргүүлэх” мэргэшлийн зэргийг 3 удаа, “Зөвлөх” мэргэшлийн зэргийг 1 удаа бататгасан багш, удирдах ажилтны мэргэшлийн зэргийн хүчинтэй хугацааг сургалтын байгууллагад ажиллах хугацаанд байнгын хүчинтэйд тооцно.

5.3.Мэргэшлийн зэрэг олгосон байгууллагын тушаалаар дараах тохиолдолд мэргэшлийн зэргийг хүчингүй болгоно:

5.3.1.төрийн албан хаагчийн болон мэргэжлийн ёс зүйн зөрчил гаргасан нь ёс зүйн хорооны дүгнэлтээр тогтоогдсон;

5.3.2.мэргэшлийн зэргийн шалгуур хангасныг нотлох баримтыг хуурамчаар бүрдүүлсэн;

5.4.Мэргэшлийн зэрэг хүчингүй болгосон тухай мэдээллийг холбогдох байгууллага нь энэ журмын 6.1-д заасан бүртгэл, мэдээллийн санд ажлын 5 хоногийн дотор бүртгэнэ.

Зургаа. Мэргэшлийн зэргийн бүртгэл, мэдээллийн сан

6.1.Боловсролын салбарын мэдээллийн систем нь багш, удирдах ажилтны мэргэшлийн зэргийн нэгдсэн бүртгэл мэдээллийг бүртгэх цахим сантай байна.



6.2. Мэргэшлийн зэргийн бүртгэл мэдээллийн цахим сан нь мэргэшлийн зэрэгтэй багш, удирдах ажилтны мэдээллийг аймаг, нийслэл, сум, дүүрэг, байгууллага, албан тушаал, ажилласан жил, мэргэшлийн зэрэг олгосон он, бататгасан давтамж зэргээр ангилж, бүлэглэж харах боломжтой, ил тод, нээлттэй байна.

6.3. Мэргэшлийн зэргийн бүртгэл мэдээллийн санг цэцэрлэгийн түвшинд эрхлэгч/арга зүйч, орон нутгийн түвшинд сургуулийн өмнөх боловсролын асуудал хариуцсан арга зүйч/мэргэжилтэн, Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад холбогдох мэргэжилтэн тус тус бүртгэж, хөтөлнө.

6.4. Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь мэргэшлийн зэрэг олгох, бататгах, хүчингүй болгох үйл ажиллагааг боловсролын мэдээллийн нэгдсэн системд тулгуурлан арга зүйн удирдлагаар хангаж, 6.2-д заасан мэдээллийг жил бүрийн 2 дугаар сард багтаан Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ.

Долоо. Бусад зүйл

7.1. Мэргэшлийн зэрэг олгох, хүчингүй болгох үйл ажиллагаатай холбоотой гомдлыг тухайн мэргэшлийн зэргийг олгох эрх бүхий албан тушаалтан хүлээн авч, ажлын 21 хоногийн дотор хянан үзэж, хариуг гомдол гаргагчид бичгээр мэдэгдэнэ.

7.2. Боловсролын газар нь "Заах аргач", Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь "Тэргүүлэх", Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь "Зөвлөх" мэргэшлийн зэрэг олгох, хүчингүй болгох үйл ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулсан эсэхэд хоёр жил тутамд хяналт, шалгалт зохион байгуулж, зөрчил гарсан тохиолдолд шийдвэр гаргасан этгээдэд хариуцлага тооцох, зөрчлийг арилгуулах, шаардлагатай тохиолдолд мэргэшлийн зэргийг хүчингүйд тооцох арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

7.3. Энэ журмын хэрэгжилтэд Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хоёр жил тутамд хяналт, шинжилгээ-үнэлгээ хийнэ.

7.4. Хөдөлмөрийн тухай хуулийн 4.1.4-т заасан ажилтны хууль ёсны эрх ашгийг төлөөлөн хамгаалах байгууллага, боловсролын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбооны төлөөлөл хөндлөнгийн хяналт тавьж болно.

7.5. Энэ журмыг зөрчсөн албан хаагч, иргэн, хуулийн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

---000---



Боловсролын сайдын
2024 оны 09 дүгээр сарын 19 ний өдрийн
А/95 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН БАГШ, УДИРДАХ АЖИЛТАНД МЭРГЭШЛИЙН ЗЭРЭГ ОЛГОХ, ХҮЧИНГҮЙ БОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг зүйл

1.1. Ерөнхий боловсролын сургуулийн багш, сургалтын менежер, захиралд мэргэшлийн зэрэг олгох, хүчингүй болгохтой холбогдон үүсэх харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Мэргэшлийн зэрэг нь ерөнхий боловсролын сургуулийн багш, сургалтын менежер, захирал (цаашид “багш, удирдах ажилтан” гэх)-ын холбогдох хууль тогтоомж болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлж, үр дүнд хүрснийг баталгаажуулах, тэдний мэргэжлийн хөгжлийг дэмжихэд чиглэнэ.

1.3. Мэргэшлийн зэрэг олгох, хүчингүй болгох үйл ажиллагаа нь багш, удирдах ажилтны ур чадвар, манлайлал, ажлын үр дүнд суурилсан, үнэн бодитой, ил тод, нээлттэй, шударга, хамтын оролцоог хангасан, аливаа хөндлөнгийн нөлөөлөл, ялгаварлан гадуурхалт болон ашиг сонирхлын зөрчлөөс ангид байна.

Тайлбар: “мэргэшлийн зэрэг олгох, хүчингүй болгох” гэдэгт мэргэшлийн зэрэг шинээр олгох, бататгах (өмнө олгосон зэргийн шалгуурыг давтан хангаж байгааг баталгаажуулах), эсхүл ахиулах, хүчингүй болгох үйл ажиллагааг хамруулна.

Хоёр. Мэргэшлийн зэргийн шатлал, хүчинтэй хугацаа

2.1. Багш, удирдах ажилтны мэргэшлийн зэрэг нь “Заах аргач”, “Тэргүүлэх”, “Зөвлөх” гэсэн шатлалтай байна.

2.2. Мэргэшлийн зэргийн хүчинтэй хугацаа шатлал бүрд 5 жил байна.

2.3. Мэргэшлийн зэргийг шатлал алгасан олгохгүй.

2.4. Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийн 9.2-д заасныг үндэслэн дараах тохиолдолд багшид мэргэшлийн зэргийг хугацаанаас нь өмнө олгож болно:

2.4.1. олон улсын түвшний шинжлэх ухааны олимпиадад бэлтгэсэн суралцагч нь медаль хүртсэн;

2.4.2. улсын төрөлжсөн олимпиадын гурвын даваанд бэлтгэсэн суралцагч, эсхүл тухайн багш өөрөө хоёр буюу түүнээс олон удаа медаль хүртсэн.

2.5. “Тэргүүлэх” мэргэшлийн зэргийг 3 удаа, “Зөвлөх” мэргэшлийн зэргийг 1 удаа бататгасан багш, удирдах ажилтны мэргэшлийн зэргийг сургалтын байгууллагад тухайн албан тушаалын үндсэн орон тоонд ажиллах хугацаанд байнгын хүчинтэйд тооцно.



Гурав. Мэргэшлийн зэрэг олгох шалгуур

3.1. Мэргэшлийн зэргийг дараах нийтлэг шаардлага болон энэ журмын 3.2-т заасан шалгуурыг бүрэн хангасан багш, удирдах ажилтанд олгоно:

3.1.1. багш мэргэжилтэй, ерөнхий боловсролын сургуульд гурваас доошгүй жил ажилласан байх;

3.1.2. тухайн албан тушаалд тавих шаардлагыг бүрэн хангасан байх;

3.1.3. тухайн албан тушаалын үндсэн орон тоонд ажилладаг байх;

3.1.4. сүүлийн нэг жилийн хугацаанд ёс зүйн зөрчил болон мэргэжлийн алдаа гаргаагүй байх;

3.1.5. мэргэшлийн зэрэг олгох, бататгах, саналыг багш нарын зөвлөлийн хуралд оролцогчдын 75-аас доошгүй хувь нь дэмжсэн байх.

3.2. Энэ журмын 3.2.1, 3.2.2, 3.2.3-т заасан шалгуурыг бүрэн хангасан багш, удирдах ажилтанд мэргэшлийн зэрэг олгоно.

3.2.1. Багшид мэргэшлийн зэрэг олгох, бататгах үйл ажиллагаанд дараах шалгуурыг баримтална:

Шалгуур	Мэргэшлийн зэргийн шатлал		
	Заах аргач	Тэргүүлэх	Зөвлөх
	Үзүүлэлт		
1. Багшийн ёс зүй, манлайлал, хандлага	<ul style="list-style-type: none"> - Хариуцлагатай - Шударга - Хамт олон, суралцагч, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчидтэй эерэг харилцаатай байх. 		
	<ul style="list-style-type: none"> - Тэгш хамруулах боловсролын үзэл санааг ойлгодог; - Суралцагчийн ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрч, бүх суралцагчид ижил тэгш, ялгаварлалгүй ханддаг байх; 	<ul style="list-style-type: none"> - Суралцагчийн ялгаатай хэрэгцээг ойлгож, тэгш хамруулах талаар бусад багш нарт зөвлөж, тусалдаг байх. 	
	<ul style="list-style-type: none"> - Сургуулийн алсын хараа, эрхэм зорилго, зорилтыг ойлгодог, хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулах эрмэлзлэлтэй байх. 	<ul style="list-style-type: none"> - Сургуулийн алсын хараа, эрхэм зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулдаг байх. 	<ul style="list-style-type: none"> - Сургуулийн алсын хараа, эрхэм зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд манлайлан ажилладаг байх.
2. Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, арга зүй	<ul style="list-style-type: none"> - Сургалтын хөтөлбөрийн дагуу хичээлийг төлөвлөн үр дүнтэй зохион байгуулдаг байх; - Хичээл, сургалт зохион байгуулахдаа суралцагчийн ялгаатай суралцахуйг харгалзаж, дэмжлэг үзүүлдэг байх; - Явцын үнэлгээг тогтмол хэрэгжүүлдэг, үр дүнд үндэслэн арга зүйгээ сайжруулдаг байх; 		
	<ul style="list-style-type: none"> - Боловсролын цахим, нээлттэй нөөцийг ашиглан сургалтын цахим 	<ul style="list-style-type: none"> - Боловсролын цахим, нээлттэй нөөц, хэрэглэгдэхүүн, үнэлгээг бүтээлчээр 	<ul style="list-style-type: none"> - Боловсролын цахим, нээлттэй нөөцийг бүрдүүлэхэд орон нутаг, үндэсний

Бүртгэлийн дугаар ... 70 ...
МОНГОЛЫН БОЛОВСРОЛЫН ШАЛГАГАЧ АЖИЛТНЫ ГАРЫН ҮСЭГ
ХУУЛЬ АЖИЛ ГЯЛГАА
 Хуулбар олгосон ажилтны гарын үсэг
 20... оны 09 сарын ...-ний өдөр

	<p>хэрэглэгдэхүүн, үнэлгээг хичээл, сургалтын үйл ажиллагаандаа хэрэгжүүлж, үр дүнг тооцсон байх;</p> <p>- Сургалтын нөөц хэрэглэгдэхүүнийг боловсруулж, хичээл сургалтын үйл ажиллагаанд үр дүнтэй ашигладаг байх;</p> <p>- Шинэлэг бүтээлч арга зүйг турших, хэрэгжүүлэх зорилгоор судалгаат хичээл зохион байгуулж, хичээлийн судалгаанд хувь нэмэр оруулдаг байх.</p>	<p>хэрэглэдэг, орон нутгийн түвшинд арга зүй, туршлагаа хуваалцдаг байх;</p> <p>- Сургалтын нөөц хэрэглэгдэхүүнийг суралцагчдын ялгаатай хэрэгцээнд тохируулан хийж, хичээл сургалтын үйл ажиллагаанд үр дүнтэй ашигладаг байх;</p> <p>- Шинэлэг бүтээлч арга зүй, технологийг турших, хэрэгжүүлэх зорилгоор хичээлийн судалгааг зохион байгуулж, үр дүнг сургууль, орон нутгийн түвшинд хэлэлцүүлсэн байх.</p>	<p>түвшинд хувь нэмэр оруулсан байх;</p> <p>- Сургалтын нөөц хэрэглэгдэхүүнийг суралцагчдын ялгаатай хэрэгцээнд тохируулан хийж, үр дүнтэй ашигладаг, арга зүй, туршлагаа орон нутаг, бүс, үндэсний түвшинд хуваалцдаг байх;</p> <p>- Шинэлэг бүтээлч арга зүй бий болгох, технологийг турших, хэрэгжүүлэх зорилгоор хичээлийн судалгааг манлайлан зохион байгуулж, үр дүнг орон нутаг, бүс үндэсний түвшинд хуваалцсан байх.</p>
<p>3. Хамтын ажиллагаа</p>	<p>- Мэргэжлийн багш нарын бүлэг, багийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог байх;</p> <p>- Хүүхдийн эрхийг хамгаалах, суралцагчдын хөгжил төлөвшлийг дэмжих, үе тэнгийн дээрэлхэлт, гадуурхал, хорт зуршил, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, суралцагчдын хөгжил төлөвшлийг дэмжихэд багш, эцэг эх, асран хамгаалагчтай хамтран ажилладаг байх;</p> <p>- Сургалтын үйл ажиллагааг сайжруулахад бусад багш нартай идэвх, санаачилгатай хамтран ажилладаг байх;</p> <p>- Хүүхдийн хөгжил, төлөвшлийг дэмжих чиглэлээр хичээлээс гадуурх үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулдаг байх.</p>	<p>- Сургууль, хамт олны тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд идэвх, санаачилгатай оролцдог байх;</p> <p>- Сургалтын чанар, үр дүнг сайжруулахад бусад багш нартай хамтран ажиллаж, арга зүй, туршлагаа сургууль, бүсийн түвшинд хуваалцдаг байх;</p> <p>- Хүүхдийн авъяас, чадвар, хөгжих хэрэгцээг судалж, илрүүлэн, хөгжүүлэх үйл ажиллагааг санаачлан зохион байгуулдаг байх.</p>	<p>- Орон нутгийн боловсрол, сургалтын байгууллагатай хамтран ажиллаж, арга зүй, туршлагаа бүс, үндэсний түвшинд хуваалцдаг байх.</p> <p>- Хүүхдийн авъяас, чадварыг хөгжүүлсэн арга зүй, туршлагаа бусад багш, бүс, орон нутгийн хэмжээнд хуваалцдаг, зөвлөн тусалж, хамтран ажилладаг байх.</p>

Бүртгэлийн дугаар **УЛСЫН БОСЛОНДОН БИ САМ**
 АТА12960 9116621
ХУУЛБАР ҮНЭН
 Хуулбар олгосон ажилтны гарын үсэг
 2024 оны 09 сарын 27-ний өдөр

3.2.1.1 Багшийн хөгжлийг дэмжих үндэсний төвийн арга зүйн эхний шатны сургалтад хамрагдаж, амжилттай төгссөн тохиолдолд “Заах аргач” мэргэшлийн зэргийн 2 дахь шалгуурыг хангасанд тооцно.

3.2.1.2 Багшийн хөгжлийг дэмжих үндэсний төвийн арга зүйн ахисан түвшний сургалтад хамрагдаж, амжилттай төгссөн тохиолдолд “Тэргүүлэх”, “Зөвлөх” мэргэшлийн зэргийн 2 дахь шалгуурыг хангасанд тооцно.

3.2.2. Сургалтын менежерт “Тэргүүлэх”, “Зөвлөх” мэргэшлийн зэрэг олгох, бататгах болон “Заах аргач” зэргийг бататгах үйл ажиллагаанд дараах шалгуурыг баримтална:

Шалгуур	Мэргэшлийн зэргийн шатлал		
	Заах аргач	Тэргүүлэх	Зөвлөх
	Үзүүлэлт		
1. Ёс зүй, хандлага, манлайлал	<ul style="list-style-type: none"> - Хамт олон багш, ажилтнуудтай эерэг, ёс зүйтэй, шударга, тэгш харилцдаг, тусалж, дэмждэг байх; - Суралцагчийн ялгаатай хэрэгцээг ойлгож, тэгш хамруулах талаар багш нарт зөвлөн тусалдаг байх; 		
	<ul style="list-style-type: none"> - Сургуулийн алсын хараа, эрхэм зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулдаг байх. 	<ul style="list-style-type: none"> - Сургуулийн алсын хараа, эрхэм зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд манлайлан ажилладаг байх. 	
2. Мэргэжил, арга зүйн дэмжлэг	<ul style="list-style-type: none"> - Сургалтын чанар, үр дүнг сайжруулах, багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжих зорилгоор улирал тутам бүх багшийн хичээлд ажиглалт хийж, зөвлөгөө өгдөг байх; - Байгууллагын өөрийн болон хөндлөнгийн үнэлгээний үр дүн, хөгжих хэрэгцээнд үндэслэн багшийн хөгжлийн үйл ажиллагааг төлөвлөж хэрэгжүүлэн, үр дүнг тооцдог байх; 		
	<ul style="list-style-type: none"> - Сургалтын чанар, үр дүнд хяналт, үнэлгээ, чанарын баталгаажуулалтыг тогтмол хийж, хариу арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлдэг байх; 	<ul style="list-style-type: none"> - Сургалтын чанар, үр дүнд дотоод хяналт, үнэлгээ, чанарын баталгаажуулалтыг тогтмол хийж, хариу арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлэн үр дүнд ахиц гарсан байх; 	
	<ul style="list-style-type: none"> - Сургалтын хөтөлбөр, арга зүй, үнэлгээний сүүлийн үеийн чиг хандлагыг судалж, сургуулийн хэмжээнд багш нартай хуваалцдаг, зөвлөн тусалдаг байх. 	<ul style="list-style-type: none"> - Сургалтын хөтөлбөр, арга зүй, үнэлгээний сүүлийн үеийн чиг хандлагыг судлан, хэрэгжүүлж, орон нутгийн бусад сургалтын байгууллага, багш нарт зөвлөн тусалдаг байх. 	<ul style="list-style-type: none"> - Сургалтын хөтөлбөр, арга зүй, үнэлгээний сүүлийн үеийн чиг хандлагыг судлан, хэрэгжүүлж, орон нутгийн боловсрол, сургалтын байгууллага, мэргэжлийн байгууллагатай хамтран түгээн дэлгэрүүлдэг байх.

ХУУЛБАР ҮНЭН
 Хуулбар олгосон ажилтны гарын үсэг
 2024 оны 09 сарын 24-ний өдөр


3. Хамтын ажиллагаа	<ul style="list-style-type: none"> - Багш, суралцагч, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчдийг сонсож, тулгамдсан асуудлыг шийдвэрлэдэг байх; - Багш нарын зөвлөл, багийн үйл ажиллагааг манлайлан зохион байгуулдаг, шийдвэр гаргахад хамтын оролцоог хангадаг байх; 		
	<ul style="list-style-type: none"> - Багшийн хөгжил, сургалтын чанар үр дүнг сайжруулах чиглэлээр сургуулийн багш нар, мэргэжлийн багш нарын бүлэг, багийг чиглүүлэн зөвлөж, хамтран ажилладаг байх. 	<ul style="list-style-type: none"> - Багшийн хөгжил, сургалтын чанар үр дүнг сайжруулах чиглэлээр орон нутгийн мэргэжлийн хөгжлийн бүлэг, бусад сургалтын байгууллагатай хамтран ажилладаг байх. 	<ul style="list-style-type: none"> - Багшийн хөгжил, сургалтын чанар үр дүнг сайжруулах чиглэлээр орон нутгийн боловсролын байгууллагатай хамтран ажилладаг байх.

3.2.2.1. Багшийн хөгжлийг дэмжих үндэсний төвийн манлайллын эхний шатны сургалтад хамрагдаж, амжилттай төгссөн тохиолдолд “Заах аргач” мэргэшлийн зэргийн 2 дахь шалгуурыг хангасанд тооцно.


3.2.2.2. Багшийн хөгжлийг дэмжих үндэсний төвийн манлайллын ахисан түвшний сургалтад хамрагдаж, амжилттай төгссөн тохиолдолд “Тэргүүлэх”, “Зөвлөх” мэргэшлийн зэргийн 2 дахь шалгуурыг хангасанд тооцно.

3.2.3. Захиралд “Зөвлөх” зэрэг олгох, бататгах болон “Тэргүүлэх” зэргийг бататгах үйл ажиллагаанд дараах шалгуурыг баримтална:

Шалгуур	Мэргэшлийн зэргийн шатлал	
	Тэргүүлэх	Зөвлөх
	Үзүүлэлт	
1. Ёс зүй, хандлага, манлайлал	<ul style="list-style-type: none"> - Хамт олон багш, ажилтнуудтай эерэг, ёс зүйтэй, шударга, тэгш харилцдаг, тусалж, дэмждэг байх; - Суралцагчийн ялгаатай хэрэгцээг ойлгож, тэгш хамруулах талаар багш нарт зөвлөн тусалдаг байх; 	
	<ul style="list-style-type: none"> - Сургалтын байгууллагын соёл, хамт олны хөгжил, төлөвшлийг үр дүнтэй чиглүүлж, бүтээлч санаачилга гарган хэрэгжүүлсэн, бусад сургалтын байгууллагад туршлагаа хуваалцсан байх. 	<ul style="list-style-type: none"> - Сургалтын байгууллагын соёл хамт олны хөгжил, төлөвшлийн чиглэлээр бий болгосон арга зүй, туршлагаа орон нутаг, бүс, үндэсний хэмжээнд хуваалцсан байх.
2. Сургалтын байгууллагын менежмент	<ul style="list-style-type: none"> - Сургуулийн алсын хараа, эрхэм зорилго, хөгжлийн зорилт, хэрэгжүүлэх арга замыг өөрийн үнэлгээ, судалгаанд үндэслэн хамтын оролцоонд тулгуурлан төлөвлөсөн байх; - Сургуулийн үйл ажиллагааны төлөвлөгөөг шаардлагын дагуу боловсруулж, биелэлтэд дүн шинжилгээ хийсэн байх; - Сургуулийн дотоод дүрэм, журмыг хууль журамд нийцүүлэн боловсруулж, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлдэг байх; - Сургуулийн жилийн төсвийг оновчтой төлөвлөж, үр ашигтай зарцуулдаг байх; 	



	<p>- Суралцагчдад үзүүлэх үйлчилгээ (хоол үйлдвэрлэл, үйлчилгээ, хамран сургах тойргийн хүүхдийг боловсролд тэгш хамруулах, хүүхэд хамгаалал, дотуур байр, номын сан, цахим, зайн хосолсон сургалтын бэлэн байдал)-ний орчин, нөхцөлийг шаардлагын дагуу бүрдүүлсэн байх.</p>
	<p>-Сургалтын чанар, үр дүн, суралцагчийн хөгжил, ахицад дүн шинжилгээ хийж, хугацаанд нь тайлагнадаг, хариу арга хэмжээ авдаг байх;</p> <p>- Багш нарын зөвлөл, сургуулийн зөвлөл, мэргэжлийн багш нарын бүлэг, мэргэжлийн хөгжлийн бүлэгт дэмжлэг үзүүлж, хамтран ажилладаг байх;</p> <p>- Багш ажлын байрандаа хамтран хөгжих орчин, нөхцөл бүрдүүлсэн байх.</p> <p>-Сургалтын чанар, үр дүн, суралцагчийн хөгжил, ахицад дүн шинжилгээ хийж, хугацаанд нь тайлагнадаг, хариу арга хэмжээ авч, үр дүнд хүрсэн байх;</p> <p>- Багш нарын зөвлөл, сургуулийн зөвлөл, мэргэжлийн багш нарын бүлэг, мэргэжлийн хөгжлийн бүлэгт дэмжлэг үзүүлж, хамтран ажилласан, арга туршлагаа орон нутаг, бүс, үндэсний хэмжээнд хуваалцсан байх;</p> <p>-Багшийн хөгжлийн чиглэлээр мэргэжлийн багш нарын бүлэг, мэргэжлийн хөгжлийн бүлэгт дэмжлэг үзүүлж, ахиц, амжилт гаргасан байх.</p>
<p>3.Хамтын ажиллагаа</p>	<p>- Багш, ажилтан, суралцагч, эцэг эх, асран хамгаалагчдыг сонсож, тулгамдсан асуудлыг шийдвэрлэдэг байх;</p> <p>- Шийдвэр гаргахад хамтын оролцоог хангадаг байх;</p> <p>- Багийн хамтын ажиллагааг үр дүнтэй чиглүүлдэг байх.</p> <p>- Багш, ажилтан, хүний нөөцийн хөгжлийн үйл ажиллагааг төлөвлөж, зохион байгуулалтад дэмжлэг үзүүлдэг байх;</p> <p>- Багш, ажилтан, хүний нөөцийн хөгжлийг төлөвлөж, зохион байгуулалтад дэмжлэг үзүүлдэг, ажлын байрны орчин нөхцөлийг сайжруулах чиглэлээр бүтээлч санаачилга гарган хэрэгжүүлсэн байх;</p> <p>- Хөгжлийн онцлог ялгаатай суралцагчдын сурах, хөгжих, тэгш хамран суралцах орчин нөхцөл бүрдүүлсэн байх;</p> <p>- Хөгжлийн онцлог ялгаатай суралцагчдын сурах, хөгжих, тэгш хамран суралцах орчин нөхцөл бүрдүүлж, бусад сургууль, орон нутаг, бүсийн хэмжээнд арга туршлагаа хуваалцсан байх;</p> <p>- Орон нутгийн боловсрол, сургалтын байгууллагатай хамтран ажиллаж, 2-оос доошгүй сургалтын байгууллагад зөвлөн тусалсан байх.</p> <p>- Бүс, үндэсний хэмжээнд боловсрол, сургалтын байгууллага, мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллаж, 3-оос доошгүй сургалтын байгууллагад зөвлөн тусалсан байх.</p>



ХУУЛБАР ҮНЭН

Хуулбар олгосон ажилтны гарын үсэг
 2024 оны 09 сарын 24 -ний өдөр

3.2.3.1. Багшийн хөгжлийг дэмжих үндэсний төвийн манлайллын ахисан түвшний сургалтад хамрагдаж, амжилттай төгссөн тохиолдолд “Тэргүүлэх”, “Зөвлөх” мэргэшлийн зэргийн 2 дахь шалгуурыг хангасанд тооцно.

Дөрөв. Мэргэшлийн зэрэг олгох, хүчингүй болгох үйл ажиллагааны зохион байгуулалт

4.1. Энэ журмын 4.4-т заасан ажлын хэсгийн санал, дүгнэлтэд үндэслэн багш, удирдах ажилтанд мэргэшлийн зэрэг олгох, хүчингүй болгох эсэх шийдвэрийг дараах эрх бүхий албан тушаалтан гаргана:

4.1.1. “Заах аргач” зэргийг сургуулийн захирал;

4.1.2. “Тэргүүлэх” зэргийг аймаг, нийслэлийн боловсролын газрын дарга;

4.1.3. “Зөвлөх” зэргийг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн.

4.2. Мэргэшлийн зэрэг олгох, бататгах хүсэлтийг багш, удирдах ажилтан томилох эрх бүхий албан тушаалтанд тухайн оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн дотор гаргана.

4.3. Энэ журмын 4.2-т заасан хугацаанд багш, удирдах ажилтан дараах баримт бичгийг цахим хэлбэрээр боловсролын салбарын мэдээллийн системд байршуулна:

4.3.1. мэргэшлийн зэрэг олгох эсхүл бататгахыг хүссэн хүсэлт;

4.3.2. энэ журмын 3.1, 3.2-т заасан шаардлага, шалгуурыг бүрэн хангасан болохыг нотлох баримт, мэдээлэл;

4.3.3. мэргэшлийн зэрэгтэй тохиолдолд мэргэшлийн зэрэг олгосон эрх бүхий албан тушаалтны албан ёсны шийдвэрийн хуулбар.

4.4. Энэ журмын 4.3-т заасан системд байршсан баримт бичгийг магадлан шалгах, үнэлэх, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг мэргэшлийн зэрэг олгох эсэх шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтан томилон ажиллуулна.

4.4.1. Ажлын хэсэг нь 5 эсхүл 7 хүний бүрэлдэхүүнтэй байна.

4.4.2. Сургуулийн ажлын хэсэгт Хөдөлмөрийн тухай хуулийн 4.1.4-т заасан “ажилтны төлөөлөл”-ийг оролцуулна.

4.4.3. Ажлын хэсгийн дарга, гишүүд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасны дагуу “Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн эсэх тухай мэдэгдэл”-ийг мэргэшлийн зэрэг олгохтой холбогдох үйл ажиллагаа эхлэхийн өмнө батлагдсан маягтын дагуу гаргаж, ажлын хэсгийн даргад хүлээлгэн өгнө.



4.4.3. Энэ журмын 3.1, 3.2-т заасан шаардлага, шалгуурыг багш, удирдах ажилтан хангасан эсэхийг ажлын хэсэг нотлох баримтад үндэслэн хянаж, үнэлэн санал, дүгнэлт гаргана.

4.4.4. Мэргэшлийн зэрэг олгох шаардлага, шалгуур хангасан багш, удирдах ажилтны холбогдох мэдээллийг боловсролын салбарын мэдээллийн системд баталгаажуулна.

4.4.5. Мэргэшлийн зэрэг олгох шаардлага, шалгуур хангасан эсэх нотлох баримтыг Боловсролын ерөнхий хуулийн 12.12, 35.5, 43.1-д заасан цахим систем, цахим мэдээллийн сангаас нягталж болно.

4.4.6. Шаардлагатай тохиолдолд мэргэшлийн зэрэг олгох шаардлага, шалгуурыг хангаж байгаа эсэхийг тухайн багш, удирдах ажилтны ажлын байранд очиж магадлан шалгах эсхүл цахим асуулга, хичээл ажиглалт болон баримт бичгийн шинжилгээ хийж болно.

4.4.7. Мэргэшлийн зэрэг олгох шаардлага, шалгуур хангаагүй үндэслэл бүхий тайлбар, зөвлөмжийг албан бичгээр, эсхүл цахим шуудангаар багш, удирдах ажилтанд хүргүүлнэ.

4.5. “Заах аргач”, “Тэргүүлэх” мэргэшлийн зэрэг олгосныг гэрчилсэн албан ёсны баталгаа нь энэ журмын 4.1.1, 4.1.2-т заасан эрх бүхий албан тушаалтны шийдвэр байна.

4.6. Энэ журмын 4.1.3-т заасан Засгийн газрын гишүүний шийдвэрт үндэслэн Зөвлөх зэрэг олгосон багш, удирдах ажилтанд мэргэшлийн зэргийн үнэмлэх олгоно.

4.6.1. Зөвлөх мэргэшлийн зэргийн үнэмлэхийн загвар батлах, хэвлүүлэх, олгох, маягтын дагуу мэдээллийн сан үүсгэх асуудлыг боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хариуцна.

4.7. Мэргэшлийн зэрэг бататгах, шатлал ахиулах хүсэлтийг мэргэшлийн зэргийн хүчинтэй хугацаанд гаргана.

4.8. Удирдах ажилтанд мэргэшлийн зэрэг олгох шаардлага, шалгуур хангасан эсэхийг аймаг, нийслэлийн боловсролын газрын даргын томилсон ажлын хэсэг магадлан шалгаж санал, дүгнэлт гаргана.

4.9. Сургуулийн ажлын хэсэг нь багшийн мэргэшлийн зэргийн шалгуур хангасан эсэх дүгнэлтийг багш нарын зөвлөлийн хуралд нээлттэй танилцуулан дүгнэлт, санал, хурлын тэмдэглэлийг нэгтгэн сургуулийн захиралд тухайн оны 04 дүгээр сард багтаан танилцуулна.

4.10. Сургуулийн захирал нь ажлын хэсгийн дүгнэлт, багш нарын зөвлөлийн хурлын шийдвэрт тус тус үндэслэн дараах шийдвэрийг ~~5 дугаар сарын эхний 7~~ хоногт багтаан гаргана:

4.10.1. шаардлага, шалгуур хангасан багшид “Заах аргач” мэргэшлийн зэрэг олгох;



4.10.2 багшийн “Тэргүүлэх”, “Зөвлөх” мэргэшлийн зэргийн шаардлага, шалгуур хангасан тухай ажлын хэсгийн дүгнэлт, санал, сургалтын менежерийн мэргэшлийн зэргийн шаардлага, шалгуур хангасан байдлыг магадлан шалгуулах хүсэлтийг тус тус аймаг, нийслэлийн Боловсролын газарт уламжлах.

4.11. Аймаг, нийслэлийн Боловсролын газрын ажлын хэсэг нь багш, удирдах ажилтанд “Тэргүүлэх”, “Зөвлөх” мэргэшлийн зэрэг олгох шалгуурыг магадлан шалгаж, дүгнэлт гаргах болон энэ журмын 4.8-д заасан үйл ажиллагааг тухайн оны 5 дугаар сард багтаан зохион байгуулна.

4.12. Аймаг, нийслэлийн Боловсролын газрын дарга нь энэ журмын 4.11-т заасан дүгнэлтэд үндэслэн дараах шийдвэрийг тухайн оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор гаргаж, холбогдох байгууллагад хүргүүлэх үйл ажиллагааг зохион байгуулна:

4.12.1. шаардлага, шалгуур хангасан багш, удирдах ажилтанд “Тэргүүлэх” мэргэшлийн зэрэг олгох;

4.12.2. сургалтын менежерийн “Заах аргач” мэргэшлийн зэрэг бататгах шаардлага, шалгуур хангасан эсэх дүгнэлтийг сургуулийн захиралд хүргүүлэх;

4.12.3. “Зөвлөх” мэргэшлийн зэргийн шаардлага, шалгуур хангасан багш, удирдах ажилтны хүсэлт, ажлын хэсгийн дүгнэлт, саналыг Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад уламжлах.


4.13. Сургуулийн захирал нь энэ журмын 4.12.2-т заасан дүгнэлтийг үндэслэн сургалтын менежерт “Заах аргач” мэргэшлийн зэргийг бататган олгох шийдвэрийг 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор гаргана.

4.14. Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын ажлын хэсэг нь багш, удирдах ажилтан “Зөвлөх” мэргэшлийн зэрэг олгох, бататгах шаардлага, шалгуур хангасан эсэхийг магадлан шалгаж, дүгнэлт гаргах, мэдээллийн системд баталгаажуулах, Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад уламжлах үйл ажиллагааг тухайн оны 09 дүгээр сарын 20-ны өдөрт багтаан зохион байгуулна.

4.15. Энэ журмын 4.14-т заасан дүгнэлт, саналд үндэслэн шаардлага, шалгуур хангасан багш, удирдах ажилтанд “Зөвлөх” мэргэшлийн зэргийг тухайн оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр олгоно.

4.16. Мэргэшлийн зэрэг олгох эрх бүхий албан тушаалтан нь ажлын хэсгийн дүгнэлт, саналыг баримт бичгийн бүрдэл хангуулахаар нэг удаа буцааж болох бөгөөд үүнээс бусад тохиолдолд буцаах, шаардлага шалгуур хангасан багш, удирдах ажилтанд мэргэшлийн зэрэг олгохоос татгалзах, шаардлага, шалгуурыг хангаагүй багш, удирдах ажилтанд мэргэшлийн зэрэг олгохыг хориглоно.

4.17. Мэргэшлийн зэрэг ахиулахаар хүсэлт гаргасан багш, удирдах ажилтан нь зэрэг ахиулах шалгуурыг хангаагүй тохиолдолд өмнө олгогдсон хүчин төгөлдөр



мэргэшлийн зэргийг 1 жилээр сунгах шийдвэрийг тухайн мэргэшлийн зэргийг олгох эрх бүхий албан тушаалтан нь тухайн оны 10 дугаар сард багтаан гаргана.

4.18. Энэ журмын 4.17-д заасан үндэслэлээр мэргэшлийн зэргийг 1-ээс олон удаа сунгахгүй.

4.19. Багш, ажилтны мэргэшлийн зэрэг олгуулах, ахиулах, бататгах хүсэлт гарган бүрдүүлсэн баримт бичиг, ажлын хэсгийн дүгнэлт, санал, мэргэшлийн зэрэг олгох шийдвэрийг байгууллагын ажлын хэсэг нь хадгаламжийн нэгж үүсгэн архивт шилжүүлнэ.

4.20. Сургууль нь мэргэшлийн зэргийн нэмэгдэлд шаардлагатай зардлыг дараа оны төсвийн төсөлд тусгаж, төлөвлөнө.

4.21. Сургууль нь мэргэшлийн зэрэг ахиулсан, шинээр авсан багш удирдах ажилтанд мэргэшлийн зэргийг нэмэгдлийг дараа оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн эрх бүхий байгууллагаас тогтоосон хувь хэмжээгээр тооцож олгоно.

4.22. Мэргэшлийн зэргийн шатлал ахиулсан багш, удирдах ажилтанд энэ журмын 4.21-д заасан нэмэгдлийг авах хүртэл хугацаанд өмнөх мэргэшлийн зэргийн нэмэгдлийг үргэлжүүлэн олгоно.

4.23. Өндөр насны тэтгэвэр тогтоолгоод сургуульд үндсэн орон тоонд ажиллаж байгаа багш, удирдах ажилтны мэргэшлийн зэргийн хүчинтэй хугацаанд нэмэгдлийг Хөдөлмөрийн тухай хуулийн 145 дугаар зүйлийн 145.2-т заасны дагуу шийдвэрлэнэ.

Тав. Мэргэшлийн зэргийг хэвээр хадгалах, хүчингүй болгох

5.1. Дараах тохиолдолд багш, удирдах ажилтны мэргэшлийн зэргийг хэвээр хадгална:

5.1.1. Хөдөлмөрийн тухай хуулийн 106.1-д заасны дагуу жирэмсний болон амаржсаны, хүүхэд асрах чөлөөтэй тохиолдолд 3 хүртэл жил;


5.1.2. Ажил олгогчийн зөвшөөрлөөр гадаад улсад мэргэжил дээшлүүлэх болон магистр, докторын түвшний сургалтад хамрагдаж байгаа тохиолдолд 3 хүртэл жил;

5.1.3. Цэргийн жинхэнэ албанд татагдсан тохиолдолд 1 жил;

5.1.4. Өөрийн болон гэр бүлийн гишүүний эрүүл мэндийн байдлын улмаас ажил олгогчоос чөлөө авсан тохиолдолд 1 жил хүртэл;

5.1.5. Боловсролын ерөнхий хуулийн 17.1, 25.1, 27.1, 28.1-д заасан байгууллагад удирдах болон гүйцэтгэх албан тушаалд дэвшиж, шилжиж, сэлгэн ажилласан тохиолдолд 5 хүртэл жил;

5.1.6. Удирдах дээд байгууллага, албан тушаалтны шийдвэрээр 2 хүртэлх жил өөр ажил үүрэг гүйцэтгэсэн тохиолдолд тухайн хугацаанд.



5.2. Мэргэшлийн зэргийн хүчинтэй хугацааг энэ журмын 5.1-д заасан хугацааг баримтлан багш, ажилтан сургуульд үндсэн орон тоонд ажиллаж ажиллаж эхэлсэн хугацаанаас эхлэн үргэлжүүлэн тооцно.

5.3. Мэргэшлийн зэрэг олгох эрх бүхий албан тушаалтан нь дараах тохиолдолд мэргэшлийн зэргийг хүчингүй болгоно:

5.3.1. Төрийн албан хаагчийн болон мэргэжлийн ёс зүйн зөрчил гаргасан нь ёс зүйн хорооны дүгнэлтээр тогтоогдсон;

5.3.2. багшлах эрхийг тодорхой хугацаагаар хасах, хязгаарлах шийдвэрийг эрх бүхий байгууллагаас гаргасан;

5.3.3. мэргэшлийн зэргийн шалгуур хангасныг нотлох баримтыг хуурамчаар бүрдүүлсэн;

5.4. Мэргэшлийн зэрэг хүчингүй болгосон тухай мэдээллийг холбогдох байгууллага нь энэ журмын 6.1-д заасан бүртгэл, мэдээллийн санд ажлын 5 хоногийн дотор бүртгэнэ.

Зургаа. Мэргэшлийн зэргийн бүртгэл, мэдээллийн сан

6.1. Боловсролын салбарын мэдээллийн систем нь багш, удирдах ажилтны мэргэшлийн зэргийн бүртгэл, мэдээллийн цахим сантай байна.

6.2. Мэргэшлийн зэргийн бүртгэл мэдээллийн цахим сан нь мэргэшлийн зэрэгтэй багш, удирдах ажилтны мэдээллийг аймаг, нийслэл, сум, дүүрэг, байгууллага, албан тушаал, ажилласан жил, мэргэшлийн зэрэг олгосон, хүчингүй болгосон шийдвэр, огноо, бататгасан давтамж, гүйцэтгэлийн үнэлгээний түвшин зэргээр ангилж, бүлэглэж харах боломжтой, ил тод, нээлттэй байна.

6.3. Мэргэшлийн зэргийн бүртгэл, мэдээллийн санг сургуулийн сургалтын менежер, аймаг, нийслэлийн боловсролын газрын сургалт, арга зүйн асуудал хариуцсан нэгж, Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын холбогдох нэгж тус тус бүртгэж, хөтөлнө.

6.4. Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь 6.3-т заасан мэдээллийн сангийн бүртгэлийг үүсгэх, хөтлөх үйл ажиллагааг нэгдсэн зохион байгуулалтаар хангаж, дүн шинжилгээ хийдэг байна.

Долоо. Бусад зүйл.

7.1. Багш, ажилтнаас зэрэг олгох, хүчингүй болгох үйл ажиллагаатай холбоотой гомдлыг тухайн мэргэшлийн зэрэг олгох эрх бүхий этгээдэд гаргаж болох бөгөөд эрх бүхий албан тушаалтан гомдлыг ажлын 21 хоногийн дотор хянан үзэж, хариуг гомдол гаргагчид бичгээр мэдэгдэнэ.

7.2. Боловсролын газар нь "Заах аргач", Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь "Тэргүүлэх", Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь "Зөвлөх" мэргэшлийн зэрэг олгох, хүчингүй болгох үйл ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулсан эсэхэд жил бүр хяналт, шалгалт зохион байгуулж, зөрчил гарсан тохиолдолд шийдвэр гаргасан

2024 оны 09 сарын 25-ний өдөр

этгээдэд хариуцлага тооцох, зөрчлийг арилгуулах, шаардлагатай тохиолдолд мэргэшлийн зэргийг хүчингүйд тооцох арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

7.3. Энэ журмын хэрэгжилтэд Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хоёр жил тутамд хяналт, шинжилгээ-үнэлгээг хийж ажиллана.

7.4. Хөдөлмөрийн тухай хуулийн 4.1.4-т заасан ажилтны хууль ёсны эрх ашгийг төлөөлөн хамгаалах байгууллага нь энэ журмын хэрэгжилтэд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлж, санал, зөвлөмж өгч болно.

7.5. Тэргүүлэх болон Зөвлөх мэргэшлийн зэрэг олгох санал, дүгнэлт гаргах ажлын хэсгийн үйл ажиллагаанд боловсролын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбооны төлөөлөл хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлж болно.

7.6. Энэ журмыг зөрчсөн албан хаагч, иргэн, хуулийн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

--- оОо ---

